



БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгууллагын нэр: "АЛТАНБУЛАГ" ЧӨЛӨӨТ БҮС

Тайланг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг



Төлөвлөгөө баталсан:

Төсвийн Шууд захирагч

"АЛТАНБУЛАГ" ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

(гарын үсэг)

/Б.АЗЖАРГАЛ/

(огноо)

Тэмдэг



2025.12.22

“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө үндэслэж бодлогын тогтоомж	байгаа баримт бичиг, хууль	болон бусад хууль	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Гүйцэтгэлийн хувь	ХШҮ хувь
						Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хүрсэн буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/		
1	2				3	4	5	6		7	8

Стратегийн төлөвлөгөөний зорилго:

Зорилго 1: Бүсийн дэд бүтэц, хөгжлийн бодлого, байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.2.212 дах заалтад “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдийн тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ.

1.1	Алтанбулаг чөлөөт бүсийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө	шинэчлэн батлуулж, бодлогын баримт бичигт тусгаж боловсруулах	-	Гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын бодлогын баримт бичгийг тусгаж Алтанбулаг чөлөөт бүсийн 2023-2025 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Шадар сайдаар батлуулсан.	100%	80%,	
1.2	Алтанбулаг чөлөөт бүсийн шинэчилсэн “Ерөнхий төлөвлөгөө”-г байгууллагаар батлуулах	“Ерөнхий холбогдох гүйцэтгүүлж	214.9 сая/ төгрөг	Гүйцэтгэлийн хувь	80% (2024)	100% (2025)	Барилга, хот байгуулалтын яамны сайдын 2022 оны А/10 дугаартай тушаалаар Алтанбулаг чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар сайдын багцаас 214.9 сая төгрөг төсөвлөгдөн Идеал групп ХХК болон Некст стейп инженеринг ХХК-ийн түншлэл шалгарч ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна. Идеал групп ХХК болон Некст стейп	85%	80%,	

						инженеринг ХХК-ний түншлэлийн гүйцэтгэж буй ерөнхий төлөвлөгөөг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Засгийн газрын хурлаар хэлэлцүүлнэ.		
1.3	Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчин боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх” журмын төсөл, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах” журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх	-	Саналын тоо	3 (2024)	3 (2025)	Монгол Улсын Шадар Сайдын ажлын албанд “Чөлөөт бүсэд мөрдөх журам” болон Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”, Чөлөөт бүсэд тамхи худалдах энгийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”-д өөрчлөлт оруулах саналыг боловсруулан хүргүүлсэн.	100%	80%.
1.4	Алтанбулаг чөлөөт бүсийн ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	- (2024)	50% (2025)	Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулахаар тусгагдсан. Алтанбулаг чөлөөт бүсэд барилгын материалын хангамжийн төв байгуулах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Койка компани судалгааны хүрээлэнгээс хийгдсэн ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулах зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах судалгааг үндэслэн 2025 оны Улсын төсөвт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн санал хүргүүлсэн ч санхүүжилт суугдаагүй тул 2026 оны Улсын төсөвт төсөл	50%	30%.

						арга хэмжээг хэрэгжүүлэх 15 тэрбум төгрөгийн төсвийн саналыг холбогдох хууль, журамд нийцүүлэн Эдийн засаг, Хөгжлийн яаманд хүргүүлсэн.		
1.5	Алтанбулаг чөлөөт бус доторх 13.8 км автозам, чөлөөт бүсээс хил хүртэлх хүзүүвчний хэсгийн 0.81 км автозамын барилгын ажлын гүйцэтгэл	120,000,0 төг	Ажлын гүйцэтгэлийн хувь	5% (2024)	50% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн 2024 оны 24/02 дугаар чөлөөт бус доторх 13.8 км авто зам, чөлөөт бүсээс хил хүртэлх 0.81 км замын авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, УТ240660094007/ЭЗХЯ202429 дугаар гэрээний дагуу зураг, төсөл боловсруулах ажлыг "Гео урбан консалтинг" ХХК гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэн 2025 оны 3 дугаар улиралд хүлээлгэн өгсөн. 2025 оны Улсын төсөвт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн санал хүргүүлсэн ч санхүүжилт суугдаагүй. 2026 оны улсын төсөвт 15.150.00 сая төгрөг суулгуулахаар санал хүргүүлсэн.	60%	35/
1.6	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хангаж, хэрэгжилтийг тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж Шадар Сайдын ажлын албанд хүргүүлэн хянуулж Шадар Сайдгаар батлуулсан. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулалтын нэгж байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж чиг үүргийн дагуу төлөвлөгөө боловсруулан Захирагчаар батлуулсан. Батлагдсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулж тухай бүр Шадар	100%	80/

					Сайдын ажлын албанд хүргүүлсэн.		
					Шадар сайдын 2025 оны 96 дугаар тушаалаар байгуулагдсан Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хантах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж 2025 оны 06 дугаар сарын 12, 08 дугаар сарын 21, 09 дүгээр сарын 05-ны өдөр ажлын хэсгийн гишүүдийн хурэнд 3, Чөлөөт бүсүүд, эдийн засгийн тусгай бүсүүдийн холбогдох албан хаагчдын оролцуулсан өргөтгөсөн хурал 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулснаар нийт 4 удаа хуралдсан. Ажлын хэсгийн гишүүд чөлөөт бүсийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудал (чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын ажил удаашралтай, үйл ажиллагаа жигдрээгүй байгаа талаар үнэлэлт дүгнэлт цаашид чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөгжлийн шинэ түвшинд хүргэх)-д шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон. Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааг гүйцэтгүүлэхээр "Монголын Хуульчдын холбоо"-той зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж тайланг хүлээн аваад байна. Энэхүү зөвлөх		
1.7	Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийх, хуулийн зүйл заалт хэрэгжиж байгаа болон хэрэгжихгүй байгаа шалтгааныг тодорхойлох, цаашид шаардлагатай хуулийн зүйл хэсгийг тодорхойлж, өөрчлөлт оруулах агуулгыг санал болгох, үзэл баримтлал боловсруулах	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	100%	70%

					үйлчилгээний багийн судалгааны ажилд ажлын хэсгийн гишүүд чөлөөт бүсийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар тус тусын саналыг боловсруулан хүргүүлж хамтран ажилласан.		
--	--	--	--	--	---	--	--

ЗОРИЛГО ХОЁР Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагааны стратеги зорилт

2.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилт								
2.1.1	Чөлөөт бүсэд бүртгэлтэй газар эзэмших, ашиглах эрх бүхий аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэж, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөж байгаа эсэхийг судалж, тодорхой болгох, ангилж эцэслэх, нэгтгэх, дээд шатны байгууллагад танилцуулж, шаардлагатай шийдвэрийг гаргах, арга хэмжээ авах	-	Дүгнэсэн гэрээний тоо	129 (2024)	129 (2025)	Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7, 8.7.1 дэх заалтуудыг үндэслэн Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар захирамжаар 2025 оны 1 дүгээр улиралд “Газар ашиглах, эзэмших” гэрээ болон “Хөрөнгө оруулалтын” гэрээ дүгнэх ажлын хэсэг байгуулагдаж холбогдох хуулийн заалтыг үндэслэж ахуй нэгжийн байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт, төлөвлөгөө гарган батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй нийт 154 нэгж талбарын 129 аж ахуй нэгжийн гэрээг дүгнэх тухай мэдэгдлийг иргэн, аж ахуй нэгжүүдэд албан бичгээр хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын гэрээ дүгнэх ажлын хүрээнд гэрээг цуцлах дүгнэлт гарсан 51 аж ахуй нэгжээс 29 аж ахуй нэгжийг цуцалж, 21 аж ахуй нэгжид төсөл хөтөлбөр эрчимжүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 2025 оны жилийн эцсийн байдлаар	100%	70%

						Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа бүртгэлтэй 106 аж ахуй нэгж байна. Аж ахуй нэгжийг үйл ажиллагаагаар ангилан үзвэл Логистик-3, Агуулах-3, Захиргаа-7, Үйлдвэр-4, Нөөц-3, Худалдаа эрхэлдэг 86 аж ахуй нэгж тус тус байна.		
	Чөлөөт бүсэд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг судлан дүн шинжилгээ хийх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, шаардагдах суурь мэдээллүүдийг нэгтгэн гаргах нөхцөлийг бүрдүүлнэ	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Монгол Улсын Шадар сайдын ажлын албанаас Чөлөөт бүсийн удирдлагуудад өгсөн үүрэг чиглэлийн дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн 2025 оны А/02 дугаар захирамжийн дагуу чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа 126 аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэж, газар ашиглалт болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарч байгаа зөрчлийг арилгахаар холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч шийдвэрлэсэн. Хөрөнгө оруулалтын гэрээ хийсэн аж ахуйн нэгжүүдийн гэрээг шинэчлэн баталгаажуулж хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна. 2025 онд хөрөнгө оруулалтын гэрээ дууссан 7 аж ахуйн нэгжийн төсөл хөтөлбөртэй танилцаж хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн байгуулсан.	100%	70%
2.1.3	Хөрөнгө хамтын өргөжүүлж, оруулалтыг нэмэгдүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	1. Чөлөөт бүсийн хүрээнд хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс болон дотоодын аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин	100%	80%

						сайд Шэнь Минь Жуань, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүн амын сангийн суурин төлөөлөгч Халид Шарифи тэргүүтэй төлөөлөгчид 2025.11.12-ны өдөр Алтанбулаг хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажил болон Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж Алтанбулаг боомт, чөлөөт бүсийн дэд бүтэц, хөгжлийн чиг хандлагын талаар хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон. 2. Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуягаар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд 2025.12.17-ны өдөр ажиллалаа. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагч Б.Азжаргал бүсийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн цаашдын чиглэлийн талаар танилцуулга хийсэн. Шадар сайд Х.Ганхуяг чөлөөт бүсийг зөвхөн татваргүй бараа худалдаалдаг бүс бус, Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг Алтанбулаг боомтоор дамжуулан Оросын Холбооны Улс болон Евро-Ази руу экспортлох боломжийг бодитоор бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатайг онцоллоо. Мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах, тэдний шаардлагад нийцсэн газар олголт, дэд бүтцийн шийдлийг боловсруулах, аймаг	
--	--	--	--	--	--	--	--

					орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран хөгжлийн бодлогыг тодорхойлох чиглэл өгсөн.		
2.1.4	Байгаль ээлтэй үр ашигтай дэвшилт технологи, барилга байгууламж, нэвтрүүлж байгалийн нөөц хэмнэж, Хог хаягдалыг ангилан ялгах систем нэвтрүүлж, хог хаягдалгүй эдийн засгийг хөгжүүлнэ	-	Хэрэгжилтийн хувь	0% (2024)	50% (2025)	60%	50%
2.2 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилт							
2.2.1	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн 2025 оны газар олголтын төлөвлөгөөг боловсруулж хуулийн хүрээнд газар ашиглах эрхийг иргэн ААН-д олгох		Иргэн, аж ахуй нэгжид олгосон газар ашиглах эрхийн тоо	154 (2024)	5 (2025)	100%	80%
	Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн байгаагаар холбоотойгоор Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйл 24.2-т (Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгох болон хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг тодорхой хугацаагаар түр зогсооно) гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж						

						байна. Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.7-д заасны дагуу ерөнхий төлөвлөгөө эцэслэн батлагдсаны дараа Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.4-т заасны дагуу төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан шинээр газар ашиглах эрхтэй болно. Өнөөдрийн байдлаар чөлөөт бүсэд 106 аж ахуйн нэгж, 126 нэгж талбарыг эзэмшиж, ашиглаж байна. Тайлант хугацаанд дараах иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн газрын эрхийг шилжүүлсэн. Үүнд: - Иргэн н.Өлзийбаар - Цахим ертөнц чөлөөт бүс ХХК - Хур ирмүүн билэг чөлөөт бүс - Хаан ертөнц чөлөөт бүс ХХК - Алтан гадас трейд ХХК		
2.2.2	Чөлөөт бүсэд хийгдэж буй цахилгаан өртөгтөлийн барилга угсралтын ажлыг гэрээний хугацаанд бүрэн дуусгаж хүлээн авах ажлыг зохион байгуулах	15,3 тэрбум төгрөг	Хэрэгжилтийн хувь	90% (2024)	100% (2025)	Чөлөөт бүсэд хийгдэж буй цахилгааны 35/10кВ-ын 2*4000кВА чадал бүхий дэд станцын тэжээл болох 4км 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын угсралтын ажил 100 хувь. • 35/10кВ-ын 2*4000кВА чадал бүхий дэд станцын угсралтын ажил 100 хувь. • 35кВ-ын Сүхбаатар 110/35/6кВ-ын дэд станцаас Алтанбулаг сум хоорондох 21,4 км 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-ын утас солих угсралтын ажил 100 хувь. • Хувиарлах байгууламж 2 ком 100	100%	90%.

					хувь • 2*630кВА чадал бүхий 8 ком ХТП маягийн дэд станц 100 хувь • 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам 100 хувь • 110/35/6кВ-ын Сүхбаатар дэд станцын өргөтгөлийн хүрээнд 2*25МВА хүчний трансформатор, 6,35,110кВ талын тоноглолуудыг тус бүр суурилуулан хүчдэлд залгасан бөгөөд хэвийн ажиллаж байна. Дээрх цахилгааны ажлыг 2025.12.22-ны өдөр Улсын комисс хүлээн авсан.			
2.2.3	"Алтанбулаг" чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн барилгын эскиз зурагт тавигдах шаардлага, барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах. Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргах, заавар зөвлөмж өгөх	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Бүсэд баригдаж байгаа барилга байгууламжийн батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаварын дагуу барилгын норм дүрмийг хангасан эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг дараах 8 аж ахуй нэгжид өгсөн. Үүнд: 1. "Жасу ба ой ЧБ" ХХК 2. "Шинэ бүс шинэ санаа" ХХК 3. "Мөнгөн бүс мөнх" ХХК 4. "Бум буянт од" ХХК 5. "Хаан ертөнц ЧБ" ХХК 6. "Голын жим ЧБ" ХХК 7. "Хур ирмүүн билэг ЧБ" ХХК 8. "Ивентус ЧБ" ХХК байна. 2025 онд чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн барилгын эскиз зураг, Архитектур төлөвлөлтийн даалгавар шинээр авахад тавигдах шаардлагын дагуу заавар зөвлөмж өгч барилгын эскиз зураг 2, Архитектур төлөвлөлтийн даалгавар 3 тус тус шинээр	100%	60%

					олгосон.		
					- Алтанбулаг чөлөөт бүсийн цэвэр усны шугам сулжээ, барилга байгууламжид ашиглалтын дүгнэлт гаргах, шалгах, ажлын төлөвлөгөөг баталгаажуулсан. - Цэвэр усны долоон худгийн барилга байгууламж, бохир усны худгуудын дээврийн төмөр усны хаялага алга болсноор ханын шавардлага нурж унасан. Гадна пасадны өнгөлгөө будаг хуурч унасан. Мөн байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан элэгдэлд орсон байдалтай байгаа тул дэд бүтцийн барилга байгууламж сэргээн засварлах ажлын санхүүжилтийг 2026 оны улсын төсөвт суулгахаар санал хүргүүлсэн. - Цэвэр усан хангамжийн 7 худгийг бүрэн ашиглалтад оруулахад техникийн шаардлага хангагдахгүй тул тус ажлыг хийж гүйцэтгэсэн "Комфорт импекс" ХХК-д албан шаардлага хүргүүлж улмаар барилгын туслан гүйцэтгэх баг 1-3-с 7 дугаар худгуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. 1-4 дүгээр худгуудын холболтын шугаман холбоосыг гүйцээсэн. 2. Далангийн шороог нөхөн сэргээсэн. 3. 1-5 дугаар худгуудын суурь цуурсан, хаяавч хөндийрснийг хайрга дайргаар дүүргэж нягтруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 4. 1-р худгийн гадар хананы хагарч		
2.2.4	"Алтанбулаг" чөлөөт бүсийн цэвэр ус хангамжийн 7 худгад түүний шугам хоолойд үзлэг шалгалт хийж, график гаргах, засвар үйлчилгээ хийн ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	100%	80%

					нурсан хэсгийг нөхөн сэргээж дахин шавардсан. 5. 1-7 дугаар хуудлуудын дотор ханын заслыг бүрэн хийж дуусгасан. 6. 1-7 дугаар хуудлуудын дээврийг бороо усны аюулаас бүрэн сэргийлж нөхөн сэргээж засварласан. 7. Засварын ажилд зориулсан дээврийн люкийг шинээр гаргасан. 8. 1-7 дугаар хуудлуудын дээврийн усны хялалтыг шинээр хийсэн			
2.2.5	Алтанбулаг чөлөөт бүсийн бохир ус хангамжийн 12 худаг түүний шугам хоолойд үзлэг шалгалт хийж, график гаргах, засвар үйлчилгээ хийн ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн дотор болон гадна хийгдсэн бохир усны худаг болон шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийх график төлөвлөгөөг батлуулсан. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу бүсийн дотор болон гадна хийгдсэн бохир усны худаг болон шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хэсэгчилсэн байдлаар 50 худагт үзлэг шалгалтыг хийсэн. Үүнээс бүсийн дотор 38 ширхэг БУХ болон БУХ хоорондын шугам хоолой, бүсийн гадна 12 ширхэг БУХ болон БУХ хоорондын шугам хоолойд тус тус үзлэг шалгалтыг хийсэн.	100%	70%
2.2.6	Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн дулааны эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. Засвар зөвлөмж тогтмол өгч тайлан гаргах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй 31 Аж ахуй нэгж бие даасан байдлаар цахилгаан халаагуур ашиглаж байна. Дээрх аж ахуй нэгжийн өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангаж ХТП-521, КТП-424 дүгээр дэд станцуудын трансформатор, хуваарилах самбарын тасалж, залгах автомат, шон,	100%	100%

					хөндийрүүлэгчийг цэвэрлэж, чангалгаа хийсэн. Үзлэгээр 3.2 га зам талбайн аж ахуй нэгжийн хуваарилгах самбарын ачаалал таслагчийн В фазд ниргэлэг үүсэж гагнагдсан байсныг үйлчилгээ хийж засварласан.			
2.2.7	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан дэд бүтцийн барилга байгууламж, хөрөнгийн ашиглалт, харуул хамгаалалт, үйлчилгээ хариуцан тогтмол үзлэг хийж, ажиллагааг /цахилгаан трансформатор, ерөнхий болон 0,4 шитнүүд, 6 квт цахилгаан дамжуулах агаарын шугам	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Барилга байгууламжийн ашиглалт бүрэн бүтэн байдалд хяналт тавих, үйл ажиллагааг хэрэгжүүлэх график төлөвлөгөөний дагуу улирал дутамд дараах үзлэг шалгалтыг хийсэн үүнд: 1. Алтанбулаг сумаас Сүхбаатар аймаг хүртлэх бохир усны насос станцын цахилгаан хангамжийн 19.8 км цахилгаан дамжуулах шугам, дэд станцын трансформаторт үзлэг хийсэн. Зөрчил доголдол илрээгүй. 2. Захирагчийн ажлын албаны байр, бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжийн цахилгааны хуваарилгах самбар, ерөнхий самбаруудад үзлэг хийсэн. Зөрчил доголдол илрээгүй. 3. Бүсийн цэвэр усны эх үүсвэрийн цахилгаан хангамжийн 11.8 км цахилгаан дамжуулах шугам, дагалдах тоноглол, дэд станцын трансформаторуудад хийсэн үзлэгээр илэрсэн зөрчил доголдлыг арилгахад шаардлагатай тооцоо судалгааг нэгтгэн гаргаж удирдлагад танилцуулсан.	100%	100%

2.2.8	Алтанбулаг чөлөөт бүсэд ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга байгуулалтын ажигд мэргэжлийн туслалцаа үзүүлэн арга зүйн зөвлөгөө өгөх, комиссын бичиг баримтын бүрдэлтэнд хяналт тавих, бүсэд ажиллах ХАБЭА зааварчилгаа өгч ажиллах	-	Ажлын гүйцэтгэлийн н хувь	100% (2024)	100% (2025)	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжийн барилга угсралтын ажил барилгын норм, стандарт шаардлагыг ханган, батлагдсан зураг төслийн дагуу хийгдэж буйд хяналт тавьж, Комисс ажилласан барилга байгууламжийн бүртгэлийг хийж, ХАБЭА зааварчилгаа өгч ажилласан. Үүнд: 1. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй 5 аж ахуй нэгжийн барилга байгууламжийн зураг төслийн бүрдүүлэх материалын жагсаалтыг гаргаж өгсөн. 2. 2025 онд барилга бүтээн байгуулалт, өргөтгөл засвар хийгдсэн нийт 7 аж ахуй нэгжид барилгын норм стандарт, материалын чанар ажлын явцад хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 3. Бүсэд барилга угсралтын ажил хийгдэж буй 3 аж ахуй нэгжийн ажигчдад ХАБЭА-ийн зааварчлага өгч хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд гарсан зөрчилгүй болно.	100%	70
2.2.9	Улсын комисс ажилласан барилга байгууламжийн эргэлтийн цэгүүдийг газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлжүүлэх	-	Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн тоо	3 (2024)	1 (2025)	Чөлөөт бүсэд 2025 онд улсын комисс хүлээн авсан барилга байгууламжийг аж ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийн дагуу барилга байгууламжийн нэгдсэн мэдээллийн санд холбогдох шаардлагын дагуу баримт материалын бүрдүүлбэр ханган бүртгүүлсэн.	100%	80%
2.2.10	Чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын	-	Гэрээний биелэлтийг дүгнэсэн	135 (2024)	129 (2025)	Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7, 8.7.1 дэх заалтуудыг үндэслэн	100%	70%

	газрын гэрээг дүгнэх		ААН- үүдийн тоо			“Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дүгээр захирамжаар 2025 оны 1 дүгээр улиралд “Газар ашиглах, эзэмших” гэрээ болон “Хөрөнгө оруулалтын” гэрээ дүгнэх ажлын хэсгийн хүрээнд холбогдох хууль заалтуудыг үндэслэл ажлын хэсгийн хурлыг явуулж аж ахуй нэгжийг дүгнэх шалгуур үзүүлэлт, ажлын хэсгийн төлөвлөгөөг нэгтгэн гаргаж батлуулсан. Чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй нийт 129 аж ахуй нэгжийн 154 нэгж талбарын гэрээ дүгнэсэн. Гэрээ дүгнэлтээр: -Цуцлах дүгнэлт гарсан 51 нэгж талбараас 29 аж ахуй нэгжийн цуцлан 21 аж ахуй нэгжид хугацаатай үүрэг өгсөн. Цуцалсан нэгж талбарын мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулсан.		
2.2.11	Цахилгаан эрчим хүчинд холбогдохыг хүссэн, бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн түр нөхцөл олгож, холболт хийлгэх, холболтын ажилд хяналт тавих	-	Аж ахуй нэгжийн тоо	3 (2024)	1 (2025)	-“Бум буянт ОД” ХХК цахилгаан эрчим хүчинд холбох хүсэлт ирүүлсний дагуу техникийн нөхцөлийг судалж холбогдох мэдээлэл өгсөн. “Бум буянт ОД” ХХК нь “Эко энова винд чөлөөт бүс” ХХК-тай цахилгааны тэжээлийн кабелиа хамтран эзэмших гэрээ байгуулж цахилгааны холболт хийгдсэн. -“Голын жим чөлөөт бүс” ХХК нь 1 дүгээр ээлжийн барилга байгууламжаа 100% сэргээгдэх эрчим хүчээр шийдэх төлөвлөгөөтэй ба 2 дугаар ээлжийн	100%	70%

					барилга байгууламжын тур цахилгааны холболтыг өргөтгөл хийж буй дэд станцаас цахилгаан эрчим хүч авах хүсэлт ирүүлсэн. - "Хаан ертөнц" ХХК-ийн техникийн нөхцөлийг боловсруулах тал дээр ААН-тэй харилцан зөвшилцөж кабелийн трасс явуулахад зөвшилцөлд хүрээгүй байна. - "Шинэ үндэс чөлөөт бүс" ХХК-ид 2025 онд 50 кВт, 2026 онд 35\10 кВт-ын цахилгаан эрчим хүчний өргөтгөл хийгдсэний дараа, барилгын бичиг баримтын бүрдүүлбэр хангагдсан үед техникийн нөхцөл өгөх боломжтой албан бичгээр мэдэгдсэн.	
--	--	--	--	--	--	--

Зорилт 2.3 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилт

2.3.1	Хүний нөөцийн систем hr.ssc.gov.mn сайтад хүний нөөцийн мэдээллийг тогтмол оруулах. Хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах meduileg.iias.mn сайтад оруулах, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем / hr.ssc.gov.mn -д албан хаагчдийн бүртгэл, хөдөлгөөн, холбогдох бичиг баримтын бүрдүүлэлтийг тогтмол оруулан мэдээллийг шинэчлэн ажилласан Хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлсэн-5, албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргасан-4 албан хаагчийн мэдүүлгийг meduileg.iias.mn сайтаар хүлээн авч баталгаажуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 3 хүний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг	100%	70%
-------	--	---	-------------------------	----------------	----------------	--	------	-----

						meduileg.iaас.mл хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан.		
2.3.2	Байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх, албан чадваржуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дэргэдэх ёс зүйн хороог 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Захирагчийн А/07 дугаартай захирамжаар 5 гишүүнтэй байгуулагдсан. Алтанбулаг чөлөөт бүс байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо байгуулагдаж ХНУМТ-д системд бүртгүүлэн тус системийн дагуу 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж байгууллагын албан хаагчдад хоёр удаа ёс зүйн сургалт хийж, төрийн бүс байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулж, улирал тутам ажлын тайланг тайлагнасан болно.	100%	100%
2.3.3	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу тодорхой арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх	-	ХАСХОМ, ХАСУМ гаргасан тоо	6 (2024)	6 (2025)	Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж албан тушаалтны мэдүүлгийг meduileg.iaас.mл сайтаар хүлээн авч баталгаажуулах ажлыг холбогдох хуулийн хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	100%	100%

2.3.4	Албан тушаалын сул орон тоог нөхөх, Төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, шинэчлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Байгууллагын батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон шалгаруулах тухай хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/451 тоот албан бичгээр хүргүүлсэн. Дээд шатны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тусгай шалгалтыг зохион байгуулаагүй болно.	100%	100%
2.3.5	Архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, дүрэм журмын дагуу явуулах.	-	Шийдвэрлэлтийн хоногийн тоо	30 (2024)	20 (2025)	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд албан хэрэг хөтлөлтийн https://er.gov.mongolia.mn/ цахим системийн функцуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж ирсэн болон явсан албан бичгийг хугацаанд нь бүртгэж хариуцсан нэгжид шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд er.gov.mongolia.mn цахим системээр Ирсэн албан бичиг-445 Явсан албан бичиг-413 Захирамж-59 Хүний нөөцийн чиглэлээр-49 Үйл ажиллагааны чиглэлээр – 95 тус тус гүйцэтгэсэн байна. Албан бичгийг ажлын 3-5 хоногт багтаан 100% шийдвэрлэсэн.	100%	100%
2.3.6	Байгууллагын ажиллагаанд дотоод хяналт хийх, сайжруулах дүгнэлт гарган ажиллах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	100% 2024	100% 2025	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн дагуу www.shilen.gov.mn сайтад тавигдсан мэдээлэлд хяналт	100%	50%

						шинжилгээ хийж ажилласан. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дэлгэрэлтэй холбогдох материал ирүүлэхийг шаардсан албан бичгийн дагуу 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний тайлан, цагийн нэгтгэл зэрэг баримт нотолгоо болох 65 хуудас материалыг хүргүүлсэн. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын шинжээч н.Бат-Очиртой улзаж тус албан хаагчийн талаар болон байгууллагын дотоод хяналт цаг ашиглалтын талаар тайлбар өгсөн. Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны нийт албан хаагчдын цагийн бүртгэл дээр хяналт шалгалт хийж албан хаагчдын ирц, идэвхийг сайжруулах талаар дүгнэлт гаргаж удирдлагад танилцуулсан. Тайлант хугацаанд зөрчилгүй ажилласан байна.		
2.3.7	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. 1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлалыг нэмэгдүүлэн төрийн албаны	100%	100%

						цалингийн нэгдсэн системд өөрчлөлт хийсэн. 2. Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв шинээр авах болон ахиулах албан хаагчдын судалгааг нэгтгэн Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 28 дугаар тушаалаар 8 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон. 3. Төрийн дээд одон медалиар шагнуулах 8 албан хаагчдын материалыг бүрдүүлэн Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанд 2025 оны 02 дугаар сард албан бичгээр хүргүүлсэн. 4. Тэтгэвэр тогтоолох насанд хүрч төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн 2 албан хаагчийн нэг удаагийн буцалтгүй тусламж, ар гэрт гачигдал гарсан 1 албан хаагчид буцалтгүй тусламж, шинээр төрсөн хүүхдэд баар хүргэж мөнгөн тэтгэмж, гадаадад мэргэжил дээшлүүлэхээр суралцаж байгаа 2 албан хаагчид албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөрийг олгосон. 5. Байгууллагын албан хаагчдыг шинээр орон сууцтай болгох болон орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор Худалдаа хөгжлийн банктэй 2025 онд хамтран ажиллах гэрээг байгуулан зээл авахад нь дэмжлэг үзүүлсэн. 6. Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн стандартын жишигт нийлүүлэх	
--	--	--	--	--	--	---	--

						ажлыг үе шаттай хэрэгжүүлэн ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр ажлын байр засварлах ажлыг 2025 оны 06 дугаар сард эхлүүлж 11 дүгээр сарын 27-нд дуусгавар болж ашиглалтад орсон.		
						7. Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, техник, тоног төхөөрөмжөөр хангахаар албан хаагчдаас санал авч 2026 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн.		
						8. Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.		
2.3.8	Газрын төлбөр барагдуулах ажлын хүрээнд шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх	136,01 0.169 төгрөг	Ажлын гүйцэтгэлийн н хувь	100% (2024)	100% (2025)	Бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг 13 аж ахуй нэгжийн 86076,8 мян төгрөгний хуримтлагдсан газрын төлбөрийн авлагаас 2025 онд 5 аж ахуй нэгжээс 8294.7 мян төгрөгний авлагыг бүрэн барагдуулсан. Өр төлбөртөй үлдсэн 8 аж ахуй нэгжийн 77782.1 мян төгрөгийн газрын төлбөрийн авлагаас 5 аж ахуй нэгж нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд, 2 аж ахуй нэгж нь Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулж байгаа, 1 аж ахуй нэгж нь 2019 онд цуцлагдсан, шүүхэд өгөхөд нотлох баримт хангалтгүй шалтгаанаар хүлээн авахгүй байгаа болно. "Эй ти эм эй икс ХХК"-ны авлага нь нийт авлагын 61.6%-ийг дангаар эзэлж байна. 2025 онд шинээр 1 аж ахуй нэгжийн /Шинобу Финанс чөлөөт бүс ХХК/ 4230.0 мян төгрөгийн газрын	70%	30%.

						төлбөрийн авлага барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2025 онд нийт 131 нэгж талбарын 115813,5 мян төгрөгийн газрын төлбөр төвлөрүүлж ажиллахаас 96 нэгж талбарын 78884,3 мян төгрөгийн төлбөр төвлөрүүлж, 28 нэгж талбарын газар эзэмших эрх цуцлагдсан газрын төлбөр нь 22259,5 мян төгрөг, 7 нэгж талбарын 19341,3 мян төгрөгийн газрын төлбөр төлөгдөөгүй байна.		
--	--	--	--	--	--	---	--	--

Зорилт 2.4 Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилт

2.4.1	Гадаад, дотоодын ААН, байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах.	-	Гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	- Оросын Холбооны Улсын Москва хотод болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 26 дугаар хуралдаанд санал бэлтгэн явуулж, тус хуралдааны тойм, мэдээг боловсруулж Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газарт явуулсан. - 26 дугаар хуралдааны протокол, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 16 дугаар хуралдааны протоколуудад Алтанбулаг чөлөөт бүсээс бэлтгэн явуулсан саналын дагуу дараах ажлын хэсэг байгуулагдсан. Үүнд: 1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлыг судлан	100%	80/.
-------	---	---	-------------------	-------------	-------------	---	------	------

					танилцуулах хамтарсан ажлын хэсгийг байгуулах тухай Шадар Сайдын ажлын алба, Боомтын Сэргэлтийн Үндэсний Хороонд хүсэлт, удирдамжийн төслийг боловсруулан хүргүүлснээр ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхшиг, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын газрын Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагч Б.Азжаргал нар Оросын Холбооны Улсын Тээврийн яамны Улсын хилийн боомтын тохижилт, төрийн бодлого, зохицуулалтын газрын захирал М.А. Кокаев тэргүүтэй төлөөлөгчдийг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авсан. Уулзалтаар Алтанбулаг чөлөөт бүсийн хилийн чанадад чиглэсэн гадаад орц, гарцыг нээх боломжийн талаар танилцуулга хийж санал солилцсон. Оросын Холбооны Улсын Тээврийн яамны зүгээс Монголын тал Алтанбулаг чөлөөт бүстэй нийлэх цэг/тэнхлэг, төслийн зураглалын мэдээллийг Оросын Холбооны Улсын холбогдох байгууллагуудад өгөхийг хүссэн. 2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 17 дугаар хуралдаанд санал оруулж мөн уг хуралдааны Монголын		
--	--	--	--	--	--	--	--

						Улсын бүрэлдэхүүнд орж хуралдаанд оролцсон. 3. Монгол Улс болон Оросын Холбооны Улс хоорондын бус нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Монгол-Оросын бус нутгийн анхдугаар чуулга уулзалт"-д 2025 оны 12 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Эрхүү хотноо зохион байгуулагдаж, "Монгол, Оросын худалдаа, аж үйлдвэрийн хамтын ажиллагааны нөөц бололцоог ашиглах нь" нэгдүгээр салбар хуралдаанд Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас илтгэл тавьж оролцсон. 4. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Узбекистаны Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаанд 2025 оны 02 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд оролцсон. 5. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ордос хотын Олон улсын худалдааг дэмжих хороогоор дамжуулан тус хотын Татварын баталгаат бүсийн удирдлагуудтай цахимаар холбоо тогтоож, албан хүсэлт, хавсралтын хамт илтгэн Алтанбулаг чөлөөт бүсийн өнөөгийн байдал хятад хэл дээрх танилцуулга, Чөлөөт бүсийн тухай хуулийг цахимаар хүргүүлж, харилцан айлчлал хийх, "Хамтын ажиллагааны гэрээ"-нд гарын үсэг	
--	--	--	--	--	--	--	--

					зурах тохиролцоонд хүрсэн. 6. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Шэнь Минь Жоаньтай ажил хэргийн уулзалт хийсэн. 10. 2025 оны 11-р сарын 12-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Шэнь Минь Жоань, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн суурин төлөөлөгч Халид Шарифи тэргүүтэй төлөөлөгчид "Алтанбулаг" чөлөөт бүсэд ажил хэргийн айлчлал хийж, тус чөлөөт бүсийн дэд бүтэц, хөгжлийн чиг хандлагын талаар танилцаж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал бодлоо солилцсон. 7. Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОИКА)-гийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч Жу Хэйн Нан болон бусад албаны хүмүүстэй Бүгд Найрамдах Солонгос Улсын чөлөөт бүсүүдийн туршлагыг авч хэрэгжүүлэх, чөлөөт бүсийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын зөвлөх, ажилтан нарыг урьж ажиллуулах талаар хэлэлцэж сургалтын төлөвлөгөөг Монгол хэл дээр орчуулж бэлтгэсэн.			
2.4.2	Төрийн байгууллагууд, МҮХАҮТ-тай	Захиргааны	Хурал, зөвлөгөө,	100% (2024)	100% (2025)	1. Боомтын Сэргэлтийн Үндэсний Хороонд Алтанбулаг чөлөөт бүсийн	100%	

хамтран ажиллах, гадаад дотоодод зохиогдож буй бизнес-форум, үзэсгэлэн яармалт оролцох ажлыг зохион байгуулах	бизнес-форум, үзэсгэлэн яармалт оролцох	хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлын хүрээнд холбогдох бичиг баримт, мэдээлэл бэлтгэн хүргүүлж, Хилийн боомтын захиргаатай тогтмол хамтын ажиллагаатай ажиллаж байна. 2. Гадаад Харилцааны Яамруу Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад харилцааны дэд сайд нарын түвшний хуралдаанд Алтанбулаг чөлөөт бүсийн гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай мэдээлэл, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай шийдвэрлэх шаардлагатай асуудал, цаашдын хамтын ажиллагаа хөгжүүлэх санал бэлтгэн явуулсан. 3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны удирдлагуудтай чөлөөт бүсийн цахимжуулалтын ажлын нэн тэргүүнд шийдэх асуудлын талаар хэлэлцсэн. 4. Сэлэнгэ аймаг дахь Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн захирагч, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын дарга, Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч болон холбогдох мэргэжилтнүүдтэй үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, санал солилцсон. 5. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, хувийн хэвшлийн төлөөлөл болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хар			100%
--	--	---	--	--	-------------

					Мөрөн мужийн төр засаг, бизнесийн төлөөлгүүдийн хооронд танилцуулга уулзалтыг 2025.04.11-ний өдөр зохион байгуулж, чөлөөт бүсийн онцлог, давуу талыг сурталчилан таниулсан. 6. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Оросын Холбооны Улсын Москва хотын Экспортын төв, Монгол дахь Оросын Холбооны Улсын Элчин сайдын яам, Монгол дахь Худалдааны төлөөлөгчийн газар хамтран Москва хотын бизнесийн төлөөллийн уулзалтанд оролцож, чөлөөт бүсийн тухай товч танилцуулга хийж, санал бодол солилцсон.		
2.4.3	Чөлөөт бүсийн үйл ажиллагааг таниулах ажлын хүрээг тэлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, www.altanbulaag.gov.mn веб сайтад байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр орчуулан байршуулж олон нийтэд цаг тухайд нь хүргэх	Гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	1. Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын 16 мэдээ, фото, видео мэдээллийг, монгол, орос, хятад, англи хэл дээр тухай бүрт хүргэсэн. 2. www.altanbulaag.gov.mn веб сайтад Захирагчийн мэндчилгээ, Захирагчийн ажлын албаны утасны жагсаалт, Цахим сэтгүүл, Бараа эрэлтийн тоон мэдээлэл, Тендерийн урилга, "Чөлөөт бүс өнөөгийн байдал 2025" мэдээллийг монгол, орос, хятад, англи хэл дээр тус тус шинэчлэн, байршуулсан. 3. Байгууллагын https://altanbulaag.gov.mn/ Үндсэн цэсэд үйл ажиллагааны ил тод байдал, эзэмшиж байгаа газрын мэдээлэл, эзэмшиж байгаа оюуны өмчийн жагсаалт, хэсгийг шинээр	100%	70%

						үүсгэж дараах мэдээллийг байршуулсан. Үүнд: - 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан байгууллагын стратеги төлөвлөгөө, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн тайлан, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт, эзэмшиж байгаа газрын мэдээлэл, эзэмшиж байгаа оюуны өмчийн жагсаалт бэлтгэсэн. 4. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://e-mongolia.mn/org/altanbulagshyult.shilen.gov.mn хуудсаар бүртгэлийг шинээр үүсгэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд нээлттэй байхаар заасан мэдээллийг байршуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 5. Шадар Сайдын Ажлын Албаны холбогдох мэдээ мэдээлэл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл, мэдээ мэдээллийг солилцож байгууллагын Фэйсбүүк болон веб сайтад байршуулсан. 6. "Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааг цахимжуулна гэх мэдээллийг MNB Монголын мэдээ, Монцамэ агентлагийн Орон нутгийн мэдээ, Nulpn.mn дараах мэдээллийн сувгаар сурталчлан таниулсан.		
--	--	--	--	--	--	---	--	--

2.4.4	Чөлөөт ажиллагааг орлуулагчдад танилцуулга бэлдэх	бүсийн хөрөнгө сурталчлах үйл	Арга хэмжээний тоо	5 (2024)	8 (2025)	7. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ордос хотын Татварын баталгаат бүсийн удирдлагууд, Бээжин хотын "BAW" авто машин үйлдвэрлэлийн олон улсын корпорацийн төлөөлөгчид, Баяннуур аймгийн "Дун Шэн" авто тээвэр, логистикийн компанийн төлөөлөгчид, Харбин хотын намын хорооны орлогч дарга, мөн хотын "Хун гуан" төвлөрсөн дулаан хангамжийн үйлдвэрийн зэрэг төлөөлөгчидөд бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг танилцуулан сурталчилж, "Хөрөнгө оруулагчдын гарын авлага", Чөлөөт бүсийн танилцуулга, "Чөлөөт бүсийн тухай хууль" зэрэг материалыг тараан мэдээ, мэдээллээр хангаж, орчуулга хийн, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. 1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын "BAW" авто машин үйлдвэрлэлийн олон улсын корпорацийн төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, холбоо тогтоосон. 2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Дун Шэн" гэх нүүрсний авто тээвэр, логистикийн компанийн төлөөлөгчидийг чөлөөт бүс дээр хүлээн авч бүсийн нөхцөл байдал, үйл ажиллагааг газар дээр нь танилцуулсан. 3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хар мөрөн мужийн Харбин хотын "Хун гуан" төвлөрсөн дулаан	100%	70%

					хангамжийн үйлдвэрийн үйлдвэрийн төлөөлөгчидөд бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулсан. 4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөлөнбуйр аймгийн Манжуур хотын хилийн чөлөөт бүстэй холбоо тогтоосон, хамтын ажиллагаа эхлүүлж, өргөжүүлж байна. 5. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монгол Өөртөө Засах Орны Хөх хотын Гаалийн баталгаат бүс болон тус чөлөөт бүс дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож, хамтран ажиллаж байна. Мөн Хөх хотын чөлөөт бүстэй "Хамтын ажиллагааны тухай" санамж бичиг боловсруулж, Монгол хэл дээрх хувийг Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газарт хянуулж байна.			
Зорилт 2.5 Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилт								
2.5.1	Чөлөөт бүсийн зорчигч тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргах, чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийн өсөлт, экспорт, импорт, бусад орны чөлөөт бүсийн үйл ажиллагааг судалж зах зээлийн боломж, эрэлт хэрэгцээг тодорхойлсон суурь судалгаатай болох		Гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсээр 2025 оны жилийн эцсийн өссөн дүнгээр нийт 407500 зорчигч үүнээс гадаад зорчигч 4950, тээврийн хэрэгсэл 117300 үүнээс гадаад тээврийн хэрэгсэл 490 тус тус нэвтэрсэн байна. 2025 оны жилийн эцсийн тоон мэдээг 2024 оны мөн үетэй харьцуулбал нэвтэрсэн зорчигч 52,3%, тээврийн хэрэгсэл 45,2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Чөлөөт бүсээр 2025 оны жилийн эцсийн байдлаар дараах 89 нэр төрлийн бараа нэвтэрсэн байна. Үүнд: ✓ Бэлэн хувцас-5	100%	70%.

					✓ Авто машин-6 ✓ Солтууруулах ундаа-6 ✓ Бараа материал-34 ✓ Гэр ахуйн бараа-8 ✓ Хүнс-35 ✓ Сигар янжуур-1 3,905,780.2кг цэвэр жинтэй 16 669 347,08\$-ийн бараа нэвтэрсэн ба 789,860кг цэвэр жинтэй 17,024,264.19\$-ийн бараа борлуулсан байна. Чөлөөт бүсээр 2025 онд нэвтэрсэн бараа, материал, борлуулалтын жилийн эцсийн тоон мэдээг 2024 оны тоон мэдээтэй харьцуулбал нэвтэрсэн бараа 22.5%, борлуулсан бараа 0,4%-иар өссөн үзүүлэлттэй байна.			
2.5.2	Байгууллагын урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүгийн жилийн батлагдсан төсвийн тодотгол, төсвийн төсөл, төсөөллийг бодитой аргачлалын дагуу төлөвлөх, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах гүйцэтгэлийг хянах	10,231 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн 2025 оны урсгал зардлын төсөв 2328.0 сая төгрөг, Хөрөнгө оруулалтын зардал 8.3 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зарцуулсан. Үүнд: Үндсэн болон нэмэгдэл цалин хөлс зардалд 1377874,2 мян төгрөг зарцуулахаас 916307,1 мян төгрөг зарцуулж 461567,7 мян төгрөгийн хэмнэлт гарган ажилласан. Монгол Улсын Засгийн газрын төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 203 дугаар тогтоолын дагуу 2025 оны 6 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголоор 151,4 сая төгрөг, 6 сараас 11 сарын хооронд нийт 5 удаа байгууллагын урсгал зардлын төсвөөс нийт 74,9 сая төгрөг тус тус буцаан татагдсан.	100%	100%

					2025 оны жилийн эцсийн байдлаар байр ашиглалттай холбоотой түрээсийн зардалд 28754.1 мян төгрөг, Шуудан холбоо, интернетийн зардалд 263.3 мян төгрөгийн өглөттэй гарч байна. Байгууллагын 2026 оны төсвийн төсөл, 2027, 2028, 2029 оны төсвийн төсөөллийг батлагдсан аргачлалын дагуу хуулийн хугацаанд нь Шадар сайдын ажлын албанд хүргүүлж ажилласан. Урсгал зардлын төсвийн саналд 2610,0 сая төгрөгийн төсвийн санал хүргүүлж, 1865,9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Хөрөнгө оруулалтын төсвийн саналд 6 ажил арга хэмжээнд 16,2 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй болно.			
2.5.3	Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэл, "Татварын тухай", "Төсвийн тухай", "Төрийн албаны тухай" хууль тогтоомжийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөх, хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж, аудитаар байгууллагаас зөрчилгүй санал дүгнэлт авах. Байгууллагын шилэн дансны мэдээллийг тогтмол хуулийн дагуу хөтөлж ажиллана	2,328,1 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг чанд дагаж мөрдөн, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөн явуулж байна. 2025 оны "Шилэн данс", Сангийн яамны https://info.shlendans.gov.mn/ сайтад тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт хэтрэлтийн шалтгаан, цалингийн гүйлгээнээс бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг сар бүр мэдээлэх ажлын хүрээнд 1 мэдээ хугацаа хоцроож оруулсан, 153 мэдээг хуулийн	50%	50%.

					хугацаанд нь тайлагнаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын шалгалт хийгдсэн. Аудитын дүгнэлтээр хязгаарлалтай дүгнэлт авсан, хязгаарлалтай санал дүгнэлтийн үндэслэл нь он дамжсан газрын төлбөрийн хуримтлагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй тул гүйцэтгэл хангалтгүй гарсан. Тус Аудитын дүгнэлтээр гарсан зөрчлийг Аудиторын зөвлөмж албан шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилгасан талаарх төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/315 дугаар албан бичгээр хүргүүлсэн.			
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1	Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах энгийн зөвшөөрлийг зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн арга хэмжээ авах	-	Хэрэгжилтийн хувь	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг 13 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлийн сунгалтын бүрдүүлбэр материалыг e-business.mn-ээр хүлээн авч хуулийн хүрээнд шаардлагад нийцэж байгаа эсэх дээр хяналт тавин шийдвэрлэсэн. Үүнд: 1. "Элзэт чөлөөт бүс" ХХК 2. "Сэжор финанс ЧБ" ХХК 3. "Тайгын шанд ЧБ" ХХК 4. "Царамт овоо ЧБ" ХХК 5. "Батсэлэнгэ ЧБ" ХХК	100%	100%

						6. "Платинум монгол ЧБ" ХХК 7. "Силк роуд интернэйшнл чөлөөт бүс" ХХК 8. Ханлиг-Өлзий ХХК 9. "Элэмэзфэйчүб" ХХК 10. "Цахим ертөнц чөлөөт бүс" ХХК 11. Өсөх буудай чөлөөт бүс" ХХК 12. Люксвүүд продуктс чөлөөт бүс" ХХК 13. Эгси кеатив бүтик" ХХК		
3.1.1	Монгол Улсын Засгийн газарт дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт санал боловсруулж тусгуулна	-	Саналын тоо	¹ (2024)	² (2025)	Монгол Улсын Засгийн газрын дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгах саналыг холбогдох шаардлагад дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд: Монгол Улсын Засгийн газрын таван жилийн үндсэн чиглэл, 2026 оны Улсын төсөвт хийж хэрэгжүүлэх ажлын төсвийн саналыг тус тус боловсруулан хүргүүлсэн.	100%	70%
3.1.2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	-	Гүйцэтгэлийн хувь	80% (2024)	100% (2025)	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн 500 га талбайн 50 га буюу 30%-д мод тарих бэлтгэл ажил хангаж Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн "Енисей" ХХК-иас үрсэлгээ, модны үр авах бэлтгэл ажлыг хангаж байна.	70%	30%
3.1.3	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал	-	Саналын тоо	² (2024)	² (2025)	Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол улсын 2026 оны төсвийн төсөлд туслуулахаар Алтанбулаг чөлөөт бүсэд хийгдэх шаардлагатай авто зам, Мэдээлэл төлө хяналтын нэгдсэн системд холбох, дулааны станцын техник	100%	100%

						эдийн засгийн үндэслэл шинэчлэх, логиستيкийн төв байгуулахад шаардлагатай Ажлын даалгавар, Зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлуудын саналыг төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн рітіs системд холбогдох шаардлагад нийцүүлэн ажил тус бүрийн мэдээллийг оруулсан. Алтанбулаг чөлөөт бүсийн 2026 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн төсөөлөлд хөрөнгө оруулалт-2, зураг төсөв ТЭЗҮ-4 буюу нийт 6 ажлын 16,281.90 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн.		
3.2	Сотгууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл болон тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг судалж ангилах, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцлах	-	Гүйцэтгэлийн хувь	100% (2024)	100% (2025)	Чөлөөт бүсэд сотгууруулах ундаа, тамхины тусгай зөвшөөрөлтэй нийт 36 аж ахуй нэгжээс хуульд заасан хугацаандаа үйл ажиллагаа явуулаагүй, гэрээний заалт зөрчсөн, 4 аж ахуй нэгжийн гэрээг цуцалсан.	100%	100%

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайбар/	Гүйцэтгэлийн хувь	ХШҮ хувь
1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ERP цахим системийн админнаар ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсийн нийт албан хаагчдад төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP хаяг нээн өгч албан хэрэг хөтлөлтийн ERP цахим системийг ашиглаж эхэлсэн.	100%	100%
2	Захирагчийн ажлын албаны албан хаагчдад хос бичгээр албан хэрэг хөтлөх сургалт зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь	-	100% (2025)	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр 2025 оны 01	100%	100%

					дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтгөн явуулна гэж заасны дагуу хос бичгээр албан бланкыг хэвлүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байна.		
3	"Алтанбулаг" Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг цахим болгох	Хэрэгжилтийн хувь	-	100% (2025)	Алтанбулаг Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг цахим болгох талаар E-Mongolia академийн мэргэжилтэн Г.Буднямтай 02 дугаар сарын 01-ний өдрөөс хамтран ажиллаж чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн бүрэн цахимаар олгож эхэлсэн.	100%	100%
4	Онцгой байдлын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" үүлзалт ярилцлагад байгууллагаа төлөөлөн оролцсон	Албан хаагчдын тоо	-	100% (2025)	Онцгой байдлын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн онцгой байдлын газраас 01 дүгээр сарын 29-ний өдөр "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" үүлзалт ярилцлагад байгууллагаа төлөөлөн оролцож Засгийн газрын 11 дүгээр байранд байрлах бүх албан байгууллагуудын хамтаар 01 дүгээр сарын 31-ний өдөр "Гамшгаас хамгаалах тактик" сургалтад алба хаагчид 100% хамрагдсан.	100%	100%
5	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивын баримт материалыг 2004-2025 оны шинэчлэн цэгцэлж Улсын архивд хүлээлгэн өгөхөөр материалыг цэгцлэх	Хэрэгжилтийн хувь	-	100% (2025)	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын 2004-2025 оны архивын баримт материалыг шинэчлэн цэгцэлж Улсын архивд хүлээлгэн өгөхөөр Архивын ерөнхий газрын мэргэжил, арга зүй, удирдлагын газрын холбогдох албан тушаалтнаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч баримт материалыг цэгцэлсэн.	100%	100%
6	Удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгавар	Хэрэгжилтийн хувь	-	100% (2025)	Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 44 дүгээр тушаал, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 27 дугаар тушаал хавсралтаар батлагдсан 200.000.000 сая.төгрөг төсөвт өртөгтэй 2025 онд санхүүжүүлэх Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Алтанбулаг чөлөөт бүсийн нэвтрэх хэсэгт "Ухаалаг гарц" байгуулах ажлын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах тендерийг "Төрийн болон орон	100%	90%

					нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд Захирагчийн А/53 захирамжийн хүрээнд 5 гишүүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулагдан амжилттай зохион байгуулж ажилласан. Уг ажлын гүйцэтгэл 90%-тай Гааль болон Хил хамгаалах байгууллагуудтай туршилт тохируулгын ажил хийгдэж байна		
7	Удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгавар	Үүрэг даалгавар цаг хугацаанд биелүүлэх	100% (2024)	100% (2025)	1. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний ажилтай холбоотой ажлын хэсгийн хүрээнд архивт хадгалагдаж буй дэд бүтэцтэй холбоотой 17 нэр төрлийн 82 ш боть материалтай нэг бүрчлэн танилцаж мэдээллийн хүснэгт бэлтгэсэн. Алтанбулаг чөлөөт бүсэд гаалийн теле хяналтын женетик нэвтрүүлэх ажлын хэсгийн хүрээнд Юнившн компаниар 2км орчим шилэн кабелийн сүлжээг татулж нийт 37 аж ахуй нэгжийг шилэн кабелийн сүлжээнд холбосон. Өнөтөх ХХК нь хяналтын нэгдсэн серверийг байгуулсан. 2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар нийслэл, дүүрэг, аймаг, сумуудын барилга байгууламжид нэгдсэн үзлэг шалгалт хийгдэх ажлын дагуу 2025 оны 1 сарын 27, 28-ны өдрүүдэд "Алтанбулаг" чөлөөт бүс дээр ажиллах болсныг хөрөнгө оруулагч ААН-д мэдээлж, Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газрын гал түймрийн Улсын хяналтын байцаагч, дэслэгч М.Мөнх-Эрдэнээс хяналтын хуудсыг авч зар мэдээлэл хүргүүлсэн. 3. "Алтанбулаг" чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны төлөөллүүд Сэлэнгэ аймгийн засаг дарга, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын удирдлагуудтай Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн удирдлагуудтай уулзалт хийх, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг хөрөнгө оруулагчидтай цаг үеийн байдал болон цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэж бүс дээр гарж буй зөрчлийг арилгах, шийдлийн талаар уулзалдсан.	100%	100%

8	Удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгавар	-	100% (2024)	100% (2025)	1. Сүхбаатар-Алтанбулаг чиглэлийн 35 кВ-ын 18 км, АС-50 утсыг АС-150 болгон шинэчлэх ажлын улмаас 5 хоног эрчим хүчгүй болоход бензин мотороор Гаалийн байгууллага, шалган нэвтрүүлэхийн үйл ажиллагааг хангаж ажилласан. 2. Бүсийн хуурай хог хаягдлын цэг болон түр нүхэн жорлонг буулгах ажлыг 2025.08.06-08.11-ний хооронд ААН-үүдийн төлөөллийн хамт хийж гүйцэтгэсэн. 3. "Алтанбулаг" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албан дижитал дэд бүтэц, цахим засаглал, инновац үйлдвэрлэл, "Алтанбулаг" чөлөөт бүсийн төрийн захиргааны байгууллага, хөрөнгө оруулагч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг цахимжуулахаар "ЦАХИМЖИЛТ 2050" ажлын хэсэг байгуулсан. Уг ажлын хүрээнд: - "Алтанбулаг" чөлөөт бүсийн зорчигч, тээврийн хэрэгслийн нэвтрэлтийг e-mongolia –ийн дан системийг ашиглан цахимжуулах. - Бараа бүртгэлийн системийг dashboard /хянах самбарт холбуулах - Чөлөөт бүсэд шилэн кабелийг хэсэгчлэн татулж, ААН-үүдийг гаалийн телекамержуулалтын genetic системд холбуулах - Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холбогдох /erp/ - Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тахи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг e-mongolia системийг ашиглан цахимжуулах. - E-GATE/ Ухаалаг хаалга / буюу чөлөөт бүсээр нэвтрэх тээврийн хэрэгслийн хянах систем. 4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Цахим Монгол үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааг цахимжуулах цогц шийдлийн талаар Цахим Хөгжил, Инновац, Харилцаа Холбооны яамны удирдлагуудтай уулзалдан чөлөөт бүсийн цахимжуулалтын ажлын нэн тэргүүнд шийдэх асуудлуудыг хэлэлцэж, судалгаа шинжилгээ хийж	100%	100%
---	---	---	-------------	-------------	---	------	------

					цаашдын ажлаа төлөвлөж явуулахаар хэлэлцсэн. 5. Шадар сайдын ажлын албанаас өгсөн шуурхай үүрэг даалгавар судалгаа, мэдээллийг нэгтгэн боловсруулж тухай бүр хургуулсан.		
9	Алтанбулаг чөлөөт бүсэд нийтийн ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэх	43420.0 мян төгрөг	100% (2024)	100% (2025)	Алтанбулаг чөлөөт бүсээр үйлчлүүлж буй иргэдэд зориулж хуучин ашиглагдаж байсан нийтийн модон ариун цэвэрийн байгууламжийг буулгаж өмнө нь ашиглагдаггүй байсан контейнерон засан сэлбэж сумын цэвэр, бохир усны төв шугамд холбож нийтийн хэрэгцээнд зориулан нийтийн бие засах газрыг шинээр ашиглалтад оруулсан. Бүсэд үйл ажиллагаа явуулж буй бүх ААН-н удирдлагуудтай уулзаж хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлсэн болно.	100%	100%
Хэрэгжилтийн ерөнхий дүн (7 зорилтын хүрээнд 42 арга хэмжээтэй)						94.8%	80.31%

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хүрсэн түвшин / Биелэлт	Гүйцэтгэлийн хувь	ХШҮ хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1.1.Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрт хамрагдах, холбогдох дүрэм журмыг судлах.	Сургалтад хамрагдсан тоо	10 (2024)	15 (2025)	Байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулсан. 1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч; 2. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч; 3. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч; 4. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч;	100%	100%

					5. АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс боловсруулсан мэдүүлэг гаргагчдад зориулсан онлайн сургалтад 9 албан хаагч; 6. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем <u>egr.e-mongolia.mn</u> сургалтад 25 албан хаагч; 7. "Гамшгаас хамгаалах тактик"-ийн сургалтад 21 албан хаагч; 8. Болорсофт ХХК-аас "Монгол бичгээр албан хэрэг хөтлөх" сургалтад 18 албан хаагч; 9. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад 3 албан хаагч; 10. Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 18 албан хаагч тусгус хамрагдсан.		
--	--	--	--	--	---	--	--